

“ХАР ХОРУМ ПРОПЕРТИЙС” ХК

2020 оны 01 дүгээр сарын 23-ны өдөр

№ТУЗТ 01/2020

Улаанбаатар хот

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

Компанийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус
хурлын тооллогын комисст өөрчлөлт оруулах
тухай

Компанийн тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.1 дэх хэсэг, Хар хорум пропертийс ХК (“Компани”)-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2020 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн хурлын тэмдэглэл болон Компанийн гаргасан энгийн хувьцааны 41.9 хувийг буюу 15’170 ширхэг энгийн хувьцааг эзэмшигч Экспонэйншл Фанд Менежмент ҮЦК ХХК-ийн 2020 оны 01 дүгээр сарын 21-ний өдрийн №01/2020 тоот “Тооллогын комисс шинээр томилох тухай” хүсэлтэд тодорхойлсон Тооллогын комиссын дарга Э. Шагдарсүрэн нь хувийн хүндэтгэн үзэх шалтгаанаар 2020 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хуралд оролцох боломжгүй болсон тухайгаа мэдэгдэж гадаад улсад зорчсон шалтгааныг тус тус үндэслэн **ТОГТООХ** нь:

1. Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2019 оны 12 дугаар сарын 14-ний өдрийн №ТУЗТ 03/2019 тоот “Компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурал зарлан хуралдуулах тухай” тогтоолын 8 дугаар зүйлд заасан компанийн Хувьцаа эзэмшигчдийн 2020 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн ээлжит бус хурлын Тооллогын комиссын даргаас Э.Шагдарсүрэн, гишүүн Э.Сод-Эрдэнийг чөлөөлсүгэй.
2. Компанийн Хувьцаа эзэмшигчдийн 2020 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн ээлжит бус хурлын Тооллогын комиссын даргаар Э. Сод-Эрдэнэ, Тооллогын комиссын гишүүнээр Д. Билгүүн нарыг тус тус сонгосугай.
3. Энэхүү тогтоолын хэрэгжилттэй холбоотойгоор Санхүүгийн зохицуулах хороо болон үнэт цаасны арилжаа эрхлэх байгууллагад холбогдох журмын дагуу мэдэгдэх, шаардлагатай бусад арга хэмжээг тухай бүр авч ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөл /Б.Батхүү/-д даалгасугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



/Б.БАТХҮҮ/